

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20.1.12, 25 дугаар зүйлийн 25.1, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийг тус тус үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Нийслэлийн удирдлагын шагналын төрөл, түүнийг олгох журмыг нэгдүгээр хавсралтаар, нэр дэвшигчийн товч танилцуулгын загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталж, 2016 оны 9 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2.Уг журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба /М.Буяндэлгэр/-д даалгасугай.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 1998 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн удирдлагын шагналын төрөл, түүнийг олгох журам” болон 2004 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 13 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн удирдлагын шагналын төрөл, түүнийг олгох журам”-уудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ц.САНДУЙ

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 09
дүгээр сарын 16-ны өдрийн 24 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ШАГНАЛЫН ТӨРӨЛ ЗҮЙЛ, ТҮҮНИЙГ ОЛГОХ ЖУРАМ

1. Нийтлэг үндэслэл

1.1.Нийслэлийн бүтээн байгуулалт, хөгжил дэвшилтэд үнэтэй хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулахтай холбогдох харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

2. Шагналын төрөл

2.1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын хамтарсан шагнал

2.1.1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 1994 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 02 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэл хотын хүндэт иргэнд өргөмжлөх, шагнах журам”-ын дагуу олгох шагнал

2.1.2.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2004 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 10 дугаар тогтоолоор батлагдсан “Хангарди одонгоор шагнах журам”-ын дагуу олгох шагнал

2.1.3.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2001 оны 4 дүгээр сарын 5 ны өдрийн 58 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн шилдэг аж ахуйн нэгж шалгаруулах журам”-ын дагуу олгох шагнал

2.1.4.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 115 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн сайн малчин”, “Нийслэлийн тэргүүний тариаланч,” “Нийслэлийн тэргүүний тариаланч хамт олон” шалгаруулах журмын дагуу олгох шагнал

2.2. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагнал

2.2.1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт тэмдэг”, 50,000 төгрөг дагалдана.

2.2.2.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт өргөмжлөл”, 40,000 төгрөг дагалдана.

2.2.3.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт үнэмлэх”, 30,000 төгрөг дагалдана.

3. Шагналд нэр дэвшигчдэд тавигдах шаардлага

3.1.Нийслэлийн “Хүндэт иргэн” өргөмжлөл нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Нийслэлийн Засаг Даргын хамтарсан дээд шагнал мөн бөгөөд салбартаа нэр хүндтэй, ажил хөдөлмөрөөр тэргүүлсэн, хотын хөгжилд онцгой

хувь нэмэр оруулсан, улсад 35-аас доошгүй жил ажилласан, Улаанбаатар хотын иргэнийг өргөмжилнө.

3.2.Нийслэлийн “Хангарди” одон нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Нийслэлийн Засаг Даргын хамтарсан нийслэлийн дээд шагнал мөн бөгөөд салбартаа нэр хүндтэй, ажил хөдөлмөрөөр тэргүүлсэн, хотын хөгжилд онцгой хувь нэмэр оруулсан улсад 25-аас доошгүй жил ажилласан Улаанбаатар хотын иргэнийг шагнаана.

3.3.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт тэмдэг”-ээр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дээд шагнал мөн бөгөөд салбартаа 15-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажиллаж хөдөлмөрийн өндөр амжилт гаргасан иргэнийг шагнаана.

3.4.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт өргөмжлөл”-өөр салбартаа 10-аас доошгүй жил ажиллаж салбарын хамт олноо ажлын үзүүлэлтээр манлайлагч иргэнийг шагнаана. Мөн нийслэлийн тэргүүний байгууллага, хамт олон, аж ахуйн нэгжийг шагнаж болно.

3.5.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт үнэмлэх”-ээр салбартаа 5-аас доошгүй жил ажиллаж хөдөлмөрийн амжилт үзүүлсэн иргэнийг шагнаана.

3.6.Улаанбаатар хотыг хөгжүүлэх үйлсэд эрхэлж буй ажил хөдөлмөрийнхөө амжилтаар онцгой хувь нэмэр оруулсан гадаадын иргэнийг “Хүндэт тэмдэг”, “Хүндэт өргөмжлөл”-өөр дагалдах мөнгөн урамшуулалгүйгээр шагнаж болно.

4.Шагналд нэр дэвшүүлэх

4.1.Шагналд нэр дэвшүүлэх хүсэлт, тодорхойлолтыг тухайн ажилтны ажилладаг байгууллага, хамт олон гаргаж, дараахь бичиг баримтыг бүрдүүлсэн байна.

- Тухайн байгууллагын хүсэлт
- Нэр дэвшигчийн анкет, мэдүүлэг /2 дугаар хавсралтаар/
- Хамт олны хурлын тэмдэглэл
- Нэр дэвшигчийн ажил байдал, амжилтын үзүүлэлтийн тухай тодорхойлолт

4.2.Дээрх баримт бичгийг бүрдүүлж тэмдэглэлт баяр ёслолын өдрөөс 21-ээс доошгүй хоногийн өмнө Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд ирүүлнэ.

4.3.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч, Төлөөлөгч, Нийслэлийн Засаг дарга нэр дэвшүүлж болно.

5.Шагнуулах хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, гардуулах

5.1.Шагнуулах хүсэлтийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны бичиг хэргийн эрхлэгч хүлээн авч Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад танилцуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаар шийдвэрлэнэ.

5.2.Шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн шагнуулах тухай тодорхойлолт, дагалдах баримт бичгийг судлан, тогтоолын төсөл боловсруулан Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргаар хянуулан хуралд оруулна. Шагнагдагсдын бүртгэлийг хөтөлнө.

5.3.Ажлын амжилт гаргасан хүмүүсийг шагнахад Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагнал хоорондын зай 2-оос доошгүй жил байх бөгөөд урьд тогтоосон амжилтыг бататган ахиулсан байна.

5.4.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналыг доороос дээш нь өгсүүлэх зарчмыг баримтална. Гэхдээ онцгой идэвх, зүтгэл, хүч чармайлт гаргаж амжилтад хүрсэн хүмүүсийг шагнахад дээрх зарчмыг баримтлахгүй байж болно.

5.5.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналаар нэхэн шагнахгүй.

5.6.Дагалдах мөнгөн урамшууллын хэмжээ инфляцийн түвшингээс шалтгаалан өөрчлөгдөж болно.

5.7.Шагналыг “Нийслэлийн өдөр” болон бусад тэмдэглэлт баяр ёслолоор Нийслэлийн төр захиргааны төв байгууллагын байранд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Нийслэлийн Засаг Дарга гардуулна. Мөн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч, Төлөөлөгч болон Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга гардуулж болно.

6.Шагналын одон, тэмдэг, өргөмжлөл, үнэмлэхийг нөхөн болон сольж олгох

6.1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналын одон, тэмдэг, өргөмжлөл, үнэмлэхийг аливаа шалтгаанаар үрэгдүүлсэн, эвдэж гэмтээсэн тохиолдолд шагналын эзэн, түүний нөхөр, эхнэр, хүүхэд, эцэг, эх, төрсөн ах эгч дүүд нь тухайн шагналын үнээр нөхөж эсвэл сольж олгож болно.

6.2.Шагналын одон, тэмдэг, өргөмжлөл, үнэмлэхийг шагналын эзэн, түүний нөхөр, эхнэр, хүүхэд, эцэг, эх, төрсөн ах эгч дүү нөхөн болон сольж авахыг хүсвэл, эвдэж гэмтээсэн нөхцөл, шалтгааныг тодорхой бичсэн өргөдөл, үнийн дүнг Хурлын байгууллагын дансанд тушаасан баримт, эвдэрч гэмтсэн, одон, тэмдэг, үнэмлэхийн хамт ажлын албанд ирүүлнэ.

6.3.Ажлын алба өргөдлийг хянан үзэж сольж олгох үндэслэлтэй гэж үзвэл Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад танилцуулж, захирамж гарган шийдвэрлэнэ.

7. Бусад

7.1. Шагналын хөрөнгийг жил бүрийн төсөвтөө тусгаж байна.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 09
дүгээр сарын 16-ны өдрийн 24 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

Шагналд нэр дэвшигчийн анкет

- 1.Овог 2. Нэр..... 3.Төрсөн огноо
4. Хүйс:..... 5.Төрсөн аймаг, сум, хот.....
6. Одоогийн харьяалал:.....
7. Регистр № 8.Боловсрол:
9. Ажилладаг салбар:.....
10. Мэргэжил:
11. Урьд болон одоо ажиллаж байгаа газар:

№	Ажлын газрын нэр	Хугацаа	Эрхэлсэн ажил
1			
2			
3			
4			
5			
6			
7			
8			

12. Урьд нь шагнагдаж байсан нийслэлийн болон бусад шагнал:

№	Шагналын нэр	Хэдэн онд
1		
2		
3		
4		

13. Шагнуулах ажлын үндэслэл, үзүүлэлт:

.....

14. Ямар шагналаар шагнуулах хамт олны санал:

15. Хамт олны саналын хувь:

16. Утасны дугаар.....

...../Тодорхойлолт гаргагч байгууллагын тамга, дарга /захирал/ -ын гарын
үсэг

...../он, сар, өдөр/